

II. Монголын дундат зууны түүхийн асуудал

МОНГОЛД ТУЛГАР ТӨР ТОГТОХ ҮЕ ДЭХ УЛС ТӨРИЙН ЗАСАГЛАЛЫН ПАТРИМОНИАЛЬ МАЯГИЙН ХЭВ ШИНЖИЙН ОНЦЛОГ

Ц.Батболд

Монгол Улсын Их Сургуулийн Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Улс төр судлалын тэнхим.

Товч утга: XII зууны сүүлч XIII зууны эхэн үеийн Монголын улс төрийн амьдралд тодорхой нөлөөлөл үзүүлж байсан нийгэм, улс төрийн сэтгэлгээний зарим нэгэн шинжүүд болон цэрэг, улс төрийн хүчиний түр тэнцвэр алдагдсанаас үүссэн улс төрийн хямралын явцад, Тэмүжингийн бүрдүүлсэн засаглалын патrimonial маягийн хэв шинжийн онцлог, ач холбогдол нь цэрэг, улс төрийн энэ хямрапд түүний товоийн гарахад онцгой нөлөөлөл үзүүлсэн юм.

Түлхүүр үг: Цэрэг, улс төрийн хүчиний тэнцвэр, тэнцвэр алдагдсан нь, ёс хонzon авах сэтгэлгээ нийгмийн үзэгдэл байсан нь, патриархаль, патrimonial маягийн хэв шинжийн онцлог, төрөө дээдлэх сэтгэлгээ, дайснаа бүрэн аюулгүй болгох үзэл баримтлал.

Нэг. XII зууны сүүл XIII зууны эхэн үеийн Монголын нийгэм улс төрийн үйл байдал, түүний хөгжил

Дотоод байдал. XII зууны дунд үе буюу Есүхэй баатрын удирдлаган дахь Хамаг Монголын ханлигийн үед Монгол нутаг дахь олон овог аймаг, ханлиг улсууд тодорхой хэмжээнд хэврэг шинж чанартай ч, цэрэг, улс төрийн хүчиний түр тэнцвэрийн байдалд оршиж байсан юм. Энэ байдал нь бага ч атугай тайван тогтвортой байдлыг бий болгохыг эрмэлзэж байсны илрэл юм. Үүний нэг тод илрэл нь Ван хан Тоорилын Хэрэйдийн ханлигийг сэргээн тогтооход Есүхэй баатрын Хамаг Монголын ханлигийн зүгээс цэрэг зэвсгийн тусламж үзүүлж байснаар илэрдэг. Монгол нутагт оршиж байсан Хамаг Монгол, Мэргэд, Хэрэйд, Найман, Татар зэрэг гол томоохон ханлигуудын хувьд хүчиний тодорхой түр тэнцвэр бий болж, нэг хэсэг хугацаанд үргэлжилж байв.

Гадаад байдал. Хойд Хятад, Киданыг эрхэндээ оруулсан Зүрчидийн Алтан улс өөрийн аюулгүй байдлаа бэхжүүлэх үүднээс Монгол нутаг дахь нүүдэлчин аймгуудын дунд яс хаян хооронд нь тэмцэлдүүлж байх сонирхолтой байсан бөгөөд энэ зорилго нь амжилттай хэрэгжиж, Хамаг Монгол, Татарыг хооронд нь өстөн дайсан болгож чадсан юм. Ингэснээр нүүдэлчин овог аймгуудын дотоод зөрчлийг хүрцатгаж, тэдний өсөн нэмэгдэж буй хүч чадлыг бууруулан аюулгүй байдлаа хангах бодлогыг хэрэгжүүлж байсан юм. Үүний нэг илрэл нь Есүхэй баатар Татаруудын гарг хорлогдсон нас барж, Тайчиудын Таргудай Хиралтугийн гарг Хамаг Монгол шилжсэнээр, ханлигийн нэр хүнд, байр суурь суларсан боловч, цэрэг улс төрийн хүчиний тэнцвэрт онцгой нөлөөлөөгүй юм.

Улс төрийн хүчиний тэнцвэр алдагдсан нь. Мэргэдүүд Бөртэ Үжинийг, Өүлэн Үжиний булаагдсаны өсийг санаж булааж авсан явдал нь их хэргийн шалтаг, сэдэл буюу Монгол нутаг дахь цэрэг, улс төрийн хүчиний тэнцвэрийг алдагдуулах үйл явцын эхлэлийг тавьжээ. Тэмүжин, Тоорил хан болон Жамухтай хүч хавсран эвсэл байгуулан Гурван Мэргэдийг довтолж, Бөртэ Үжинийг буцаан авсан явдал нь Монгол нутагт томоохон цэрэг, улс төрийн эвсэл үүсгэж, хүчиний тэнцвэрийг алдагдуулав. Тэмүжин энэ нөхцлийг ашиглан алдагдсан ханлигийг буцаан олж авах тэмцлээ шургуу эхлэсэн бөгөөд түүний

хүчирхэгжихийг Мэргэд, Татар аймгууд, Жамух болон Тайчууд нар хүсэхгүй байсан явдал нь Монгол дахь цэрэг улс төрийн тэмцлийг гүнзгийрүүлсэн юм.

XII зууны сүүл XIII зууны эхэн үеийн Монголын нийгэм улс төрийн байдал тогтвортгүй, ард түмний амьдрал туйлын бэрх, тайван амьдрах нөхцөлгүй байсныг "Монголын нууц товчоо"-нд өгүүлснээр:

... Хөрст дэлхий хөрвөж
Хөвчин улс хямралдаж
Хөнжилдөө унтах завгүй
Хөнөөлдөн тэмцэлдэж байв¹... гэж бичсэн байdag.

Энэ нь Монгол дахь нийгэм, улс төрийн хямрал гүнзгийрснийг илтгэх бөгөөд энэ хямрал нь нэгдсэн нэг төр улсыг байгуулах үйл явцад эргэлт буцалтгүй шилжүүлсэн юм. Тухайн үеийн нийгэм, улс төрийн хямрал нь цэрэг, улс төрийн хүчний харьцаагаар шийдвэрлэгдэж байсан бөгөөд Монгол нутагт нэг л ноёрхогч тодрон гарахаас өөр нөхцөлгүй бодит байдлыг аажимдаа бий болгосон юм. Гэвч энэ тэмцэлд Жамух, Тоорил, Тэмүжин нарын олон өрсөлдөгчдийн хэн ялах нь тодорхойгүй байсан юм. Тэмүжиний хувьд эдгээр өрсөлдөгч нараас хүн, хүч, дэмжигч нарын хувьд ч аль ч талаараа дутуу байсан бөгөөд яаж, ялан дийлж, бүхнийг араасаа дагуулж чадсан нь түүний дан ганц харизматик лидерийн авьяас чадвартай холбоотой бус юм гэдгийг гаргаж ирэхэд энэ өгүүллийн агуулга оршино. Гэхдээ энэ нь Чингис хааны харизматик лидерийн шинжийн тухай үгүйсгэсэн хэрэг биш юм.

Энэ тэмцэлд Тэмүжин тодрон гарах үндсэн нөхцлүүдийн нэг нь түүний үйл ажиллагааны олон талын дотроос засаглалын хувьд патримониаль маягийн төрийн эхэн үеийн хэв шинжийг бүрдүүлсэнээр, өрсөлдөгчдөөсөө давуу болж чадсан явдал юм. Энэ өгүүлэл нь бид Чингис хаан засаглалын хувьд патримониаль маягийн төрийн эхэн үеийн хэв шинжийг ямар хүчин зүйлийн үндсэн дээр бүрдүүлэх болсон болон түүний үр дүнд өрсөлдөгчдөөсөө давуу болж, улс төрийн тэмцэлд ялж гарахад хэрхэн нөлөөлсөнийг нь авч үзнэ. Гэхдээ үүний өмнө тухайн цаг үеийн монголчуудын нийгэм, улс төрийн сэтгэлгээний хүчин зүйлүүдийн зарим нэг онцлог, Тэмүжингийн улс төрийн үзэл баримтлалын зарим чиглэлийг товч дурдах нь тухайн цаг үеийн нөхцөл байдлыг илүү ойлгомжтой төсөөллүүлэх болов уу гэж бодож байна. Нөгөө талаар доорх нийгэм улс төрийн сэтгэлгээ, болон үзэл баримтлалын хүчин зүйлүүд нь зарим талаар улс төрийн үйл явцад хэрхэн нөлөөлж, байсан нь илрэх болно.

Хоёр. Монголчуудын нийгэм - улс төрийн сэтгэлгээний зарим онцлог

Баатар хэмээх ойлголт ба сэтгэлгээ: Тухайн цаг үед ард түмний тайван амьдрах нөхцөл нь нэгдсэн тулгар төрийн тухай хүсэл мөрөөдөл байсан юм. Ямар нэгэн шинэ үзэл баримтлал нь хэн нэгэн улс төрийн хошуучлагч түүнийг амьдралд дуудан, улс төрийн амьдралын хүчин зүйл болгон хувиргах хүртэл тодорхой хугацаанд далд хэлбэртэй байдаг². Энэхүү хүсэл мөрөөдөл нь үлгэр домгийн болон аман зохиолын хэлбэрээр ирэн гарч байсан бөгөөд үүнд талын зоригт язгууртан баатар төрөн гарч, улс орныг нэгтгэн, ард олныг

... Гар газар
Хөл хөсөр³... амруулах тухай сэтгэлгээ байсан юм.

Монгол хүүхдүүдийн дунд багаасаа баатрыг дуурайх хүсэл мөрөөдөл нь тэдний ахуй амьдрал, үе уламжлагдаж ирсэн үлгэр домог, тууль аман зохиол, томчуюудын хүмүүжүүлэх нөлөө, баатар хүмүүсийг хүндэтгэх байдлын бахархал,

¹ Монголын нууц товчоо. Ц.Дамдинсүрэнгийн орчуулга. УБ., 1947, 1976.

² Улс төрийн шинжлэх ухаан. УБ., 2001, т. 225

³ Монголын нууц товчоо. Ц.Дамдинсүрэнгийн орчуулга. УБ., 1947, 1976.

зэргээс үндэслэн түгээмэл үзэгдэл байжээ. Энэ нь нөгөө талаар өнөөгийн монгол эрэгтэй хүүхэд бүр барилддагтай адил, тухайн үеийн хүүхдүүд харвах намнах, барилдах, моринд эрэмгий байдал нь тэдний ахуй амьдралын нөхцлөес гадна, баатарлаг үйлс, баатарлаг эрчүүдийг бахархан, дуурайх сэтгэлгээгээр хүмүүжиж байсантай холбоотой бөгөөд орчин үеийнхээр бол мэргэжлийн цэрэг болон бэлтгэгдэж байсан юм. Нийгмийн сэтгэлгээний даган дуурайх хүмүүжүүлэх нөлөөлөл нь тухайн нийгмийн улс төрийн сэтгэлгээний суурь үндсийг тодорхой хэмжээнд бий болгодог байна. Тухайлбал, АНУ-ын ХМТ-ны захирал Эдгар Хувер 1980-аад онд өөрийн байгууллагын архивыг зохиолч Кортни Куперт нээж өгсөн бөгөөд энэ нь авилгал, шудрага бус явдалд идэгдсэн ХМТ-ны ажлыг авилгалын бус зоригтой, мэргэжлийн хүч болгон харуулж, өөрийг нь шүүмжлэгчдийн шүүмжлэлийг бууруулах зорилго тавьсан явдал байсан юм. Ингэснээр К.Купер З ном, 4 кино зохиол бүтээж, бас олон өгүүллийг бичсэн юм. Энэ нь тодорхой амжилтанд хүрч Холливудын анхааралыг багагүй татах, түүний уран бүтээлийн хүчийг ийш нь нилээд татсан юм. Үүний үр дүнд ХМТ-ны залуу үе тодорхой хэмжээнд хүмүүжиж эхэлсэн бөгөөд олон түмний ХМТ-нд итгэх итгэл эрс нэмэгдсэн байна. Үүний нэг адил аливаа нийгэмд тодорхой нэг даган дуурайх, дэмжин хөгжүүлэх сэтгэлгээ хөгждөг бөгөөд энэ нь тодорхой хэмжээний сэтгэлгээний маркетинг орчин бий болгодог байна. Өөрөөр хэлбэл, Битлз, чөлөөт бөх, сумо зэрэг нь тодорхой амжилтанд хүрсэн үедээ олон түмнийг өөртөө дагуулан татдагийг бид мэднэ. Үүн лугаа адил Тайчуудын гараас мултарч чадсан бяцхан хүүгийн зориг самбаа олон хүүхэд, залуучууд, хүмүүсийн хүндэтгэл бишрэл бахархалыг төрүүлж байсан нь эргэлзээгүй юм. Тухайн үеийн ард түмний дундах аман цуу яриа, домог, үлгэр нь орчин үеийн мэдээллийн үүрэг гүйцэтгэж, улс төрийн сэтгэлгээний тодорхой суурь үндсийг тавихад багагүй нөлөөлж байсан юм.

Энэ нь хэн нэгэн улс төрийн хошуучлагчийг даган цэрэг, улс төрийн үйл явцад идэвхитэй оролцоход, сэтгэл зүйн болон бие бялдар, ур чадварын бэлэн байдалд байсан гэж үзэж болох юм. Энэ талаар Лувсанчойндонгийн "Монгол зан аалийн ойлбор", Ч.Жүгдэр багшийн "Монголд феодализм тогтох үеийн нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээ" зэрэг бүтээлүүдэд нилээд тодорхой дурьдсан байдаг.

Монголчуудын баатар хэмээх ойлголт нь улс төрийн хошуучлагч, бүр бишрэн дагах, ер бусын харизматик хошуучлагчийн дүр төрхийг хүлээж байсан юм. Энэхүү цаг үеийн нийгэм, улс төрийн тогтвортгуй байдал нь ард олны сэтгэлгээний бодит биелэл болох Тэмүжин, Тоорил, Жамух нарын зэрэг талын язгууртан баатрууд өөр өөрийн замаар, өөр өөрсдийн дэмжигчдийн хамт тэмцэн гарч ирж, хошуучлахад зохих хэмжээгээр нөлөөлөөд зогсохгүй, улс төрийн сэтгэлгээний нэг суурь болсон юм.

Өс хонзон авах сэтгэлгээ нь нийгмийн үзэгдэл байсан нь:

Аливаа ард түмэн, хүмүүсийн нийтлэг оршин байгаа нөхцөлд хүмүүсийн дунд нийтийн ёс суртахуун тухайн нийгэмдээ зохицон оршин үйлчилж байдаг бөлгөө. Аливаа ард түмний дунд нийгмийн харилцаа, шашин, ахуй амьдрал, байгаль цаг уур болон бусад олон хүчин зүйлийн нөлөөгөөр ёс суртахууны тодорхой хэмжүүр хадгалагдан үлдэж, уламжлагдаж байдаг. Мөн цаг хугацаа, нийгмийн харилцааны өөрчлөлтөөс арилж үгүй болдог ёс суртахууны хэв шинжүүд байдаг. Нийгмийн харилцааг зохицуулах хууль эрх зүйн хүчин зүйл тодорхой хэмжээнд бүрдээгүй нөхцөлд, аливаа тулгамдсан болон сэтгэл зүйн цочроо өгсөн үйлдэл, үйл явцад сэтгэлийн хөөрлөөр хариу өгдөг нь хүний төрөлх мөн чанар юм. Энэ нь уламжлагдан ирэхээр нийгмийн ёс суртахууны хүчтэй инстенк үйлдэл болдог бөгөөд хувь хүний оюун ухаанд захирагддаггүй байна. Өөрөөр хэлбэл, хүн цохивол, хариу цохих, эсвэл амийг амиар гэх мэт олон хэлбэрээр илэрдэг бөгөөд энэ үед хүний цөс нь хөөрч, зүрх нь дэлсэн,

өөрийн оюун ухаангүй, араатан шинжтэй үйлдлийг хийдэг байна. Уг үйлдэл нь, хууль эрх зүйн орчин бүрдэж төлөвшөөгүй болон нэгдсэн нэг төрийн хууль идэвхитэй үйлчлээгүй нөхцөлд шудрага ёсны хэмжүүр болдог байна. Тодруулбал, ямарваа нэгэн хууль эрх зүйн орчин бүрдээгүй нөхцөлд хэн нэгэн этгээд эсвэл бүлэг хүмүүс малчныг алаад, малыг нь хулгайлах буюу дээрэмдэн авахад, малаа дээрэмдүүлсэн хүмүүс тэдгээр дээрэмчдийн эсрэг хариу ийм үйлдэл хийх нь зайлшгүй юм. Энэ нь нэгдүгээрт шудрага ёсонд нийцнэ. Учир нь нэг талаар эд хөрөнгөө буцааж авч хохиролгүй болох, нөгөө талаар амь үргэдсэн хүний ар гэрийн гомдлыг таслах арга буюу өөрөөр хэлбэл, хэргийг шүүн барагдуулж буй хэлбэр байсан юм. Хоёрдугаарт тэдний нэр хүндтэй холбоотой юм. Учир нь энэ хэргийг хэрэгсэхгүй орхивол, нэг талаар хулгай, дээрэм, аллага хядлага давтагдах, нөгөө талаар тэдгээр дээрэмдүүлсэн хүмүүсийн сул доройг нийтэд илтгэн харуулах болно. Харин хүчирхэг, хэрцгий хариуг өгч чадвал, хэрэг давтагдахгүйгээс гадна тэдний нэр хүнд өсөж, хэн ч үл халдана. Ийм байдлаар өс хонзон авах үзэгдэл тодорхой хугацаанд уламжлагдан ирдэг. Энэ нь удаан үргэлжилбэл, нийгмийн нэр хүндийн асуудал, нийгмийн үзэгдэл болтлсо туйлширдаг байна. Монголчуудын иймэрхүү өс хонzon бүхий хоорондоо дайсагнах үзэгдлийн ул мөр, үлдэгдэл миний мэдэхээр XX зууны 60-70-аад оны хүүхдүүдийн дунд үзэгддэг байсан билээ. Жишээлбэл, дунд сургуулийн ялангуяа бага ангийн хүүхдүүд хэзээ, хэнээс нь уламжлагдан ирсэн нь үл ойлгогдох, анги бүлгээрээ хоорондоо дайсагнан зодолдох явдал хэдэн жилээр тасралтгүй үргэлжлэх явдлаар илэрдэг байсан. Өнөө үед хуулийг олон түмэнд таниулж, ойлгуулан хэрэгжүүлэх болсон үед ийм байдал үүсэхгүй нь ойлгомжтой юм. Харин хууль эрх зүйн харилцааг сайн мэдэхгүй болон хуулиа ард түмэндээ таниулдаггүй, битүү айдын сэтгэхүйгээр тэднийг барьж байхыг зоридог нийгэмд ийм байдал тодорхой хэмжээнд үүсч байдаг. Өнөөдөр ийм үзэгдлийн ул мөр Умард Кавказад амь бөхтэй оршсоор байгаа бөгөөд үүний учир шалтгаан хэд хэдэн хүчин зүйлүүдтэй холбоотой юм. Үүнд: 1.) Эдгээр үндэстнүүд нь олон зууны турш өөрийн гэсэн төр улсгүй оршиж ирсэн явдал юм. Энэ нь тэдгээр ард түмний онцлогт тохирсон өөрийн хууль, эрх зүйн орчин бүрдээгүй, бусдын хууль эрх зүйн орчин оновчтой бус байсан. 2.) Энэ үзэгдэл нь хувийн шинж чанартайгаар олон жил үе уламжлагдан ирснээр нэр хүндийн асуудалтай холбогдсон. Өөрөөр хэлбэл, шударга бус явдлын эсрэг өс хонзон эс авбал, түүний гэр бүлийн нэр хүнд, нийгэмд эзлэх байр суурь, оршин тогтох явдалд муугаар нөлөөлнө гэж үздэг явдал юм.

XIII зууны эхэн үеийн монголчуудын сэтгэхүйд өс хонзон авах явдал бол өвөг дээдсийн болон өөрсдийн өмнөөс хийж байгаа ёс суртахууны шудрага хэрэг, үүргээ гүйцэтгэж буй явдал, нөгөө талаар нийгмийн нэр төрийн хэрэг юм гэж хүлээн зөвшөөрөгдөх байснаас гадна энэ үзэгдэл нь олон түмнийг өөртөө татах, дайчлах, уриалан дуудах тодорхой хүч болж байжээ. Өөрөөр хэлбэл, өнөөгийн хүмүүсийн зохион байгуулдаг, нийллэг, цайллагад эс оролцох нь нэр хүндийн төдийгүй, зохион байгуулагчид, хамт олон болон уригчийг эс хүндэтгэсэн үзэгдэл болдог. Үүнтэй адил өсийг нь өсөлж, хяслийг нь хясах их үйлсэд эс оролцох нь нэр хүндийн болон үүргээ биелүүлээгүй сул дорой байдлын илрэл болдог байв. Тухайлбал, 1206 онд байгуулагдсан шинэ тулгар Монгол улсыг Алтан улс хүлээн зөвшөөрөхгүй байсан бөгөөд тэд Монголын эсрэг дайтах аятай цагийг хүлээсний эцэст элчээ явуулан хүлээн зөвшөөхгүй байгаагаа илэрхийлэн алба гувчуур төлөхийг шаардаж байсан юм. Гэвч Чингис хаан Алтан улстай дайтах нь зайлшгүй гэдгийг ойлгож байсан боловч тэдний довтлохыг хүлээлгүй өрсөн довтлох нь стратегийн хувьд ашигтай гэдгийг олон түмэнд тайлбарлах нь төвөгтэй байсан бөгөөд харин модон илжгэнд хадуулж үхсэн Амбагай хааны өшөөг авахыг уриалсан явдал нь монголчуудын дайнч омгийн цөсийг хөөргөж, өөрийн шийдвэрийг лигитимжуулж чадсан юм.

Гурав. Чингис хааны улс төрийн үзэл баримтлалаас: Төрөө дээдлэх сэтгэлгээ

Монгол нутагт үргэлжилж байсан олон жилийн хямралт байдал нь харц ард нь эзэн ноёндоо үнэнч бус, эхнэр, нөхөр нь бие биеэндээ үнэнч бус, эмс хүүхэд нь ахмадаа хүндэтгэхгүй, эх захаа алдсаныг харуулж байсан бөгөөд Чингис хаан үүнээс гарах ганц арга бол

Цэр нь цээжин

Бөгс нь бөөрөнд байх сэтгэлгээ буюу эхнэр нь нөхрөө, хүүхэд нь эцэг эх, ахмад настнаа хүндэтгэх, албат нь эзнээс хүндэтгэж, үнэнч зүтгэх явдал гэж үзэж байсан. Үүнээс Тэмүжин эзэн ноён бол төрийн нэг хэсэг, хаан бол төрийн тэргүүн, хаан болон эзэн ноёндоо зүтгэнэ гэдэг бол төрдөө зүтгэж буй явдал мөн. Хаан болон эзэндээ тэрсэлсэн хүн бол төрийн эсрэг тэрсэлсэн гэж үзэж түүнийг алах ёстой. Харь дайсан ч байсан эзэндээ үнэнч байна гэдэг бол төрдөө үнэнч байна гэсэн үг. Эзнээсээ урvasан боол төрөөсөө урvasантай адил учраас ийм хүнд итгэж болохгүй. Ийм хүнийг устгах нь төрийг цэвэрлэж, тогтвортой болгож буй хэлбэр гэж үзэж байв. Иймээс монголчуудын төрөө дээдлэх сэтгэлгээ нь эзэндээ үнэнч зүтгэх сэтгэлгээтэй холбоотой байсан юм. Үүний дунд жирийн ард түмний дунд урваж шарвахыг үл тэвчих үзэл бүрэлдэн тогтсон байна. Гэвч ард түмний энэ сэтгэлгээ нь XV-XVII зууны үед монголчуудад их гай зовлон авчирсан юм. Учир нь ард түмэн эзэн ноёныхоо улс төрийн үйлдэл, үзэл бодол зөв эсэхийг шүүн тунгаадаггүйгээр хүчин зүтгэдэг байсан явдал юм. Ард түмний амар тайван амьдрахыг хүссэн сэтгэлгээ нь нэгдсэн нэг төртэй, дотоодын дайн, хямралгүй тогтвортой төрийг хүсэж, түүнд үнэнчээр зүтгэж ирсэнтэй холбостойгоор төр улсаа дээдлэх болсон юм. Үүний өнөөгийн нэг илрэл нь “төрийн сүлд өршөө” гэдэг үг юм.

Дайснаа бүрэн аюулгүй болгох үзэл баримтлал нь Монголчуудад бүр эрт. Хүннүгийн үеэс уламжлагдаж ирсэн бөгөөд үүнийг Чингис хаан амьдралаараа таньж мэдэн бүрэн ашиглаж чадаж байсан юм. Эрт Хүннүгийн үеэс өмнө болон хойших хугацаанд ч Монгол Хятад хоёр хоорондоо олон удаа дайтаж байсан бөгөөд Хятадын Цинь Ши Хуанди хойд зүгийн мөнхийн дайсан нүүдэлчдийг бүр мөсөн зүйл дуусгахаар их цэрэг дайчилж, дайлан орж ирсэн бөгөөд Сэлэнгэ мөрний бэлчир хүртэл давшсан боловч дайсантайгаа тодорхой шийдвэрлэх байлдаан хийж чадалгүй, намар орой болгож, улмаар ухрах замдаа бараг бүх цэргээ байн, байн гэнэтийн хөдөлгөөнт довтолгоонд өртүүлэн хядуулсаар амь мэнд зугтан харьжээ. Үүнээс үндэслэн хойд зүгийн нүүдэлчдээс хамгаалах сайн арга бол их хэрэм барих явдал мөн гэж үзсэн байдаг. Учир нь Монголчуудыг хэзээ ч бүрэн буц цохин устгаж чадахгүй бөгөөд тэд хaa нэг тийш зайллан зугтаад эрт, орой хэзээ нэгэн цагт эргээд довтлоод ороод ирнэ гэсэн үг юм. Харин Чингис хаан үүнийг сайн мэдэх бөгөөд дайснаа гээг даран хөөж бүрэн устгах ёстой гэдэг үзэл баримтлалтай байсан бөгөөд ингэснээр ч амжилтанд хүрч байжээ. Тухайлбал, Хүчүлүгийг дараахаар Зэвийг Хар Лео улсад, Султан Мухамедийг бүрэн устгахаар Зэв, Сүбээдэй хоёрыг Каспийн тэнгис тойруулан түүнийг элдүүлж байсан байдаг. Чингис хаанаас хойш ч Монголчууд энэ уламжлалаа баримтлан Кипчак, Комануудын үлдэгдлийг Унгарын Белагаас тушаан өгөхийг шаардсан бөгөөд тэд шаардлагыг нь биелүүлээгүйгээс монгол цэрэг Европт цөмрөх шалтгаан болсон байдаг. Мөн Оростой тулалдсан тулалдаан ч үүнтэй холбоотой байдаг. Учир нь манай дайсныг өмгөөлөлдөө авсан улс бол бидний дайсан байх нь зайлшгүй. Эрт орой хэзээ нэг цагт бидэнд дайсагнах болно. Боломж байвал “барын зулзагыг бага дээр нь” гэгчээр эртхэн дарж байх хэрэгтэй гэж үздэгтэй холбоотой юм. Аливаа улс төрийн үзэгдэл, үйл явцыг урьдчилан тааварлах аргагүй боловч,

тэдгээрийн чиг хандлагыг улс төрийн идэвхтэй субъектүүдийн үзэл баримтлалаар баримжаалж болдог. Үүнээс үзвэл Орос, Дорнод Европ зэрэг бусад орныг эзлэн авсан явдал нь эзлэн түрэмгийлэх зорилго агуулаагүй харин аюулгүй оршин тогтох, өөрөөр хэлбэл дайснаа бүрэн аюулгүй болгох үзэл баримтлалтай холбоотой байсан гэж үзэж болох юм.

**Дөрөв. Засаглалын патримониаль маягийн төрийн эхэн
үеийн хэв шинжийг бүрдүүлсэн нь**

Германы судлаач М.Вебер аж үйлдвэржүүлэлтийн үеийн рационал бюрократыг судлахдаа түүний өмнөх өөрөөр хэлбэл капитализмын өмнөх зурvas үе буюу абсалют хаант засаглалын үеийн түшмэдүүдийг өв, үе залгамжилсан уламжлалт “патримониаль бюрократ” гэж нэрлэжээ. Энэ нь эрх мэдэл, хүчний хувьд бие даасан хүчирхэг, уламжлалт язгууртнуудыг шахах зорилгоор эзэн хаанаас хараат төрийн түшмэдүүдийг бүрдүүлэх, язгуур угсааны цол хэргээний эзэн хааны зүгээс олгож, өв залгамжлах эрхийг нь баталгаажуулах болон хүчингүй болгож байх системийг бүрдүүлэн, төрийн засаглалыг хаанаас хараат түшмэдүүдээр гүйцэтгүүлэн улс орныг хяналтандaa авч, тогтвортой засаглалыг бий болгох зорилго агуулж байсан европын XVII-XVIII зууны үеийн бюрократизмээс өмнөх төрийн хэв шинжийг ийнхүү нэрлэжээ. (Патриархия- гэдэг нь Грек үг бөгөөд эцгийн эрхт овог, угсаа залгамжилсан тодорхой хэмжээнд бие даасан язгууртнууд бүхий төр нийгмийн тухай ойлголт юм. Харин Патримониаль- гэдэг нь латин гаралтай өмч болон өв залгамжлах, гэсэн утгатай үг бөгөөд өв залгамжилсан хэргэм зэрэг бүхий түшмэдүүдтэй нэг хүний засаглалыг хэлж буй хэрэг юм. Энэ нь аажимдаа абсалют хаант засгийн шинж төрхийг бүрдүүлдэг.)

Тэмүжин засаглалын бүх эзэн хааны гарг байх боломжтой бүх нөхцлийг аль XIII зуунд бүрдүүлж чадсан юм. Үүнд: **Нэг.** Хаан эзэн болон эзэн ноёндоо үнэнч хүмүүст итгэл хүлээлгэж, дээгүүр албанд тавих болон ийм хүмүүсийг өршөөн хэлтрүүлэх явдал нь хаан эзэн болон эзэн ноёндоо үнэнч зүтгэх нь төр улсдаа үнэнч зүтгэж буй хэлбэр мөн гэсэн сэтгэлгээг бий болгож байсан. Жишээ нь: Таргудайг тавьж явуулсан Наяаг итгэлтэй хүн гэж үзэж сүүлд төвийн түмний ноён болгож байсан юм. Энэхүү эзэн, төрдөө үнэнч байх сэтгэлгээ нь негөө талаар түүний өрсөлдөгчид болох Ван хан, Жамуха нараас, удирдлага зохион байгуулалтын хувьд давуу болоод зогсохгүй дотоод зөрчлийг багасгаснаар, тэмцэлд ялахад тодорхой хэмжээнд нелөөлсөн юм. **Хоёр.** Хааны зарлиг, шийдвэрээс өөр шийдвэр гарахыг үл хүлцэх байдал нь нэгдсэн нэг удирдлагатай болгож чадсан юм. Жишээ нь: Бидүгүн их дуулгаваргүй тул би буруушааж, мянганы ноён болгосонгүй. Чи түүнийг сургаж үз. Тэр чамтай зөвшиж нэг мянганыг захирч явтугай. Бидүгүнийг хойшид ямар болохыг бид үзээ¹ гэжээ. Гэтэл Ван хан өөрийн үзэл бодол шийдвэрээс олонтаа эргэж буцаж байсан нь МНТ-нд тод томруун дүрслэгдсэн байдаг. Чингис хаан цэрэг дайны болон бусад аливаа чухал шийдвэрийг гаргахдаа ноёд язгууртнуудын саналыг авдаг ч **эцсийн шийдвэрийг өөрөө гаргадаг** байв. Тухайлбал, Найманы Хүгсэү Сабрагт эмс хүүхдээ алдсан Ван хаанд дөрвөн хүлэг баатараа явуулан туслах шийдвэрийг бүх ноёдын эсэргүүцсээр байхад Чингис хаан өөрөө гаргасан юм. Ингэснээр Ван хааны туйлбаргүй байдалд ч ёс зүйгээ алдахгүй байгаагаа харуулснаар Хэрэйдийн хүн амын дэмжлэгийг далдуур хүлээсэн бөгөөд түүний амь нас болон ялалтанд багагүй тус нэмэр болсон байна. Харин Хэрэйдийн Ван хаан, нялх Сэнгүм, Жаха Хамбу, мөн Найманы Таян хаан, Хүчүлүг хан, Хорису-бэчи нарын удирдлагын зөрчил тэдний ялагдалд тодорхой хэмжээнд нелөөлсөн юм. **Гурав.** Эрх мэдэл бүхий

¹ Монголын нууц товчоо. УБ., 1990. № 188.

ноёд язгууртнууд, цэргийн жанжид нь эзэн хаанд үнэнч зүтгэдэгт гол утга учир нь оршдог. Яагаад гэвэл, эзэн хаан өөрийн итгэлт нөхөд, эзэндээ үнэнч боолуудыг дэвшүүлэн төрийн хэргийг гүйцэтгүүлдэг бөгөөд **тэднийг зайлцуулах нь түүнд хялбар байдаг**. Учир нь тэд уламжлалт язгууртнууд шиг бие даасан хүчин биш байсан юм. Харин уламжлалт язгууртнууд түүнд үнэнч захирагддаггүй байв. Учир нь тэд өөрийн харьяат албат иргэд, цэрэг зэвсэгтэй бие даасан хүчин тул хаашаа ч хувирах боломжтой байсан юм. Тухайлбал, Алтан, Хучир нарын урвалт юм. Мөн Жамухыг дагасан олон аймгуудын сурвалжтангууд түүнийг тууштай дэмжээгүй явдал, түүний удаа дараагийн ялагдалд нөлөөлсөн байна. Өөрөөр хэлбэл, Жамухын шийдвэр таалагдаагүй нөхцөлд, тэд тулалдааны талбарт ч, тайван цагт ч түүнийг орхин одоход бэлэн байсан юм. **Дөрөв.** Патримониаль буюу өв залгамжилсан эзэн хаан өөрийн харьяат нутгийн цэрэг, эдийн засгийн хүч, нөөцийг бүрэн эзэмшиж, түүний мэдэлд улс орны цэргийн бүх хүч байдаг бөгөөд иймээс ч улс орны **дотоод байдал тогтвортой байдаг** байна. Учир нь тайж язгууртнууд бие хамгаалах баг цэргээс өөр хувийн цэргийн хүчгүй байх явдал юм. Тэмүжин уламжлалт язгуур угсаатнуудын нэр хүндийг харгалзан үзэж, тэдэнд тодорхой хэмжээнд тулгуурлаж, өөрийн хүчийг нэмэгдүүлж байсан боловч тэдэнд бүрэн итгэдэггүй байв. Тэд үнэнч бус тууштай дэмжигч бус гэдэг нь аливаа хүндрэл бэрхшээлтэй цаг үе бүрд илрэн гарч байсан юм. Харин өөртөө үнэн ч нөхөд болон боол-сайд түшмэдүүдэд илүү эрх мэдлийг өгсөнөөр сурвалжит язгууртнуудын хүнээс эмээхгүй болдог төдийгүй тэдний эрх мэдлийг шахан бууруулах бодит нөхцлийг олж авсан байна. Нөгөө талаар эзэн хаан өөрийн итгэлт нөхөд, эзэндээ үнэнч боолуудыг дэвшүүлэн төрийн хэргийг гүйцэтгүүлдэг байсан явдал нь эдгээр ноёд язгууртнуудын нийгэмд эзлэх байр суурь, хүч нөөцөө бие даан нэмэгдүүлэх боломжоор хомс болгосон юм. Ийм учраас тэд уламжлалт үеийн бие даасан язгууртнууд шиг эзэн хаанд хүндрэл учруулдаггүй тул, улс орны дотоод байдал тогтвортой, эзэн хааныг **эсэргүүцэх бодит хүч** улс орны дотор тэр бүр бүрэлдэн **тогтох боломжгүй** болдог байна.

Тав. Чингис хаан бүх Монголыг нэгтгэсний дараа хүн амыг мянгатын ноёдуудад жижиглэн хувааж өгснөөр, бие даасан эсэргүүцэх том хүчин гарч ирэх боломжгүй болгосон юм. Энэ нь “хуваа захир” гэдэг зарчмийг оновчтой ашиглаж, улс орны **эдийн засгийн болон хүн амын нөөцийг хааны мэдэлд үндсэндээ бүрэн** оруулсан юм. Ингэснээр ноёд язгууртнууд өөрсдийн байр суурь, хүч нөөцөө нэмэгдүүлэх боломж нь эзэн хаанаас хараат болсон болсон төдийгүй шинэ ноёлогч анги буюу элитүүд бүрэлдэн тогтох эхэлсэн бөгөөд тэдний урамшил нь тодорхой хугацаанд төр улс, эзэн хаандаа үнэнч зүтгэх үндсэн нөхцөл болсон юм.

Чингис хааны засаглал дахь уламжлалт бус (патримониаль) хэв маягийн төрийн удирдлагын гол ялгаатай шинжүүдийг, уламжлалт (патриархаль) шинжид харьцуулснийг доорх хүснэгтээр харуулав.

Уламжлалт (патриархаль) болон уламжлалт бус (патримониаль) хэв маягийн төрийн удирдлагын гол ялгаатай шинжүүд:

Уламжлалт буюу патриархаль	Патримониаль хэв маягийн эхэн үе
Засаглалын бүх эрх хааны гарч байх боломж бага байдаг. Учир нь эрх ямба бүхий ноёд язгууртнууд эзэн хааныг хүлээн зөвшөөрдөг ч хэрвээ өөрсдийн эрх ашиг хөндөгдсөн тохиолдолд хааны эсрэг хүчин болох боломжтой байдаг.	Засаглалын бүх эрх эзэн хааны гарч байх боломжтой. Учир нь эрх ямба бүхий ноёд язгууртнууд эзэн хаанд үнэнч зүтгэдэгт гол утга учир нь оршдог. Яагаад гэвэл, эзэн хаан өөрийн итгэлт нөхөд, эзэндээ үнэнч боолуудыг дэвшүүлэн төрийн хэргийг гүйцэтгүүлж, эрх ямба олгодог бөгөөд тэднийг зайлцуулах нь түүнд хялбар

	байдаг.
Хаан дайны цагийн болон бусад аливаа чухал шийдвэрийг гаргахдаа ноёд язгууртнуудын хүч, дэмжлэгийг авч байж сая үйл ажиллагаа нь хүчирхэг болдог. Эс тэгвэл хааны зарлиг шийдвэр хэрэгжин биелэх нь муу байдаг.	Эзэн хаан цэрэг дайны болон бусад аливаа чухал шийдвэрийг гаргахдаа ноёд язгууртнуудын саналыг авдаг ч эцсийн шийдвэрийг өөрөө гаргадаг.
Хааны мэдэлд улс орны цэргийн бүх хүч байдаггүй. Яагаад гэвэл ноёд язгууртнууд өөр өөрийн арми буюу хувийн цэргийн хүчтэй байдаг.	Эзэн хааны мэдэлд улс орны цэргийн бүх хүч байдаг бөгөөд иймээс ч улс орны дотоод байдал тогтвортой байдаг. Учир нь тайж язгууртнууд бие хамгаалах баг цэргээс өөр хувийн цэргийн хүчгүй байдаг.
Угсаа залгамжилсан ноёд, тайж, язгууртнууд өөрийн харьяат нутгийн цэрэг эдийн засгийн хүч, нөөц болон уламжлалт язгуур угсааны нэр хүнд зэргээ бие даан нэмэгдүүлэх боломжтой бөгөөд хаанд шадарлан эрх мэдлээ улам нэмэгдүүлдэг.	Эзэн хаан угсаа, өв залгамжилсан ноёд, тайж, язгууртнууд өөрийн харьяат нутгийн цэрэг эдийн засгийн хүч, нөөцийг бүрэн эзэмшдэг бөгөөд уламжлалт язгуур угсаатнуудын нэр хүндийг харгалzan үздэг ч тэдэнд хэт эрх мэдэл өгдөггүй бөгөөд шаардлагатай бол тэдний эрхийг хязгаарладаг.
Улс орны хүн ам, эдийн засгийн нөөц хааны мэдэлд бүрэн байдаггүй. Учир нь өөр өөрийн албат ард, нутаг дэвсгэртэй, ноёд язгууртнууд эдийн засгийн болон хүн ам зүйн нөөцөө өөрсдийгөө бэхжүүлэхэд зориулдаг бөгөөд хааны санд зөвхөн өөрсдийн санаанд нийцсэн татвар төлдөг.	Улс орны эдийн засгийн болон хүн амын нөөц хааны бүрэн мэдэлд байдаг. Учир нь тайж, язгууртнууд харьяат нутгийн нөөцийг эзэн хааны санд татварын журмаар нийлүүлдэг бөгөөд өөрсдөө зөвхөн уdam угсаат гэр бүлүүдээ тэтгэн тэжээх нөөцийг эзэмшдэг. Өөрөөр хэлбэл, харьяат нутгийг захирсанаар нэг ёсондоо гэр бүлүүдээ тэжээн тэтгэх өргөн боломж нь тэдний хөдөлмөрийн хөлс болдог. Нөгөө талаар тэдгээр ноёд язгууртнууд өөрсдийн байр суурь, хүч нөөцөө нэмэгдүүлэх боломж нь хомс буюу эзэн хаанаас хараат байдаг.
Хаан эсэргүүцсэн ноёдын эсрэг тодорхой хүчтэй ч үүнийг үргэлж хэрэглэх боломжгүй байдаг тул тэдгээр ноёдын саналыг харгалзан үзэхээс аргагүй байдаг. Учир нь: Хаан эсэргүүцэгчдийг удаа дараалан дарж, хатуу ширүүн цээрлүүлж, бусдад сургамж болгож чадлаа ч гэсэн түүний төр тогтвортгүй болж, байнгын нууц сөрөг хүчинтэй болдог бөгөөд энэ нь түүнийг амьдад нь эсвэл үхсэний дараа угсаа залгамжлалыг нь өөрчилдөг.	Эзэн хаан ноёд язгууртнуудад өөрсдийн байр суурь, хүч нөөцөө нэмэгдүүлэх боломж нь хязгаарлагдмал буюу эзэн хаанаас хараат байдаг учраас уламжлалт үеийн бие даасан язгууртнууд шиг эзэн хаанд хүндрэл учруулдаггүй тул улс орны дотоод байдал тогтвортой, эсэргүүцэх бодит хүч улс орны дотор тэр бүр бүрэлдэн тогтох боломжгүй болдог байна.

Эдгээр патrimonial маягийн төрийн бүтцийн үндсэн хэв шинжүүд нь Чингис хааны улс төрийн үйл ажиллагаанд зохих хэмжээгээр нааштай нөлөөлсөн юм. Энэ (ideal-type) хэв шинжийг Тэмүжингийн ахуй амьдрал, үйлдэл

нь өөрөө бүрдүүлж өгөх гол нөхцөл нь болсон байна. Тэмүжингийн "сүүдэрнээсээ өөр нөхөргүй, сүүлнээсээ өөр ташуургүй" гэгчээр явах үед нөхөрлөсөн Боорчи болон бусад нөхдүүд нь түүний зориг тэвчээр, зорилгодоо хүрэх эрмэлзэл, ёс суртахууны шудрага чанар, удирдан жолоодох авьяас чадвар, ард түмний дундах түүний нэр хүндийг (хариизмыг) үнэлж, тэмцэн ирж, хамтран зүтгэх болсон нь энэ хэв шинжийг нийгмийн үүднээс өөрийн эрхгүй бүрдүүлэхэд хүргэсэн юм. Нөгөө талаар Тэмүжин жирийн хүмүүсийн амьдралаар амьдарч, тэдний дунд байснаар олон түмний сэтгэлгээний онцлогийг таньж мэдсэн нь цаашдын улс төрийн үйл явцдаа өөрийн байр суурь, үзэл бодлоо төлөвшүүлэх болон зорилгоо хэрэгжүүлэхэд оновчтой шийдвэр гаргахад нь тодорхой тус нэмэр болж байсан юм. Өөрөөр хэлбэл, Чингис хааны төрийн тухай болон дайснаа бүрэн аюулгүй болгох үзэл баримтлал, ард түмний сэтгэлгээний үнэт зүйлсийн итгэл үнэмшил бөөгийн шашин болон ёс суртахуунд хэрхэн тулгуурлаж байгаа болон ард түмэн ямар хүнийг хүсэмжилж байгааг мэдэрсэн зэргээс гадна нийгмийн ёс авах сэтгэлгээ нь нэр төр болон үүргийн шинжтэйг сайн таньж мэдсэн байв. Нийгмийн эдгээр үзэгдлүүдийг таньж мэдсэнээр, улс төрийн үйл явц дахь шийдвэрийг өөрийн улс төрийн үзэл баримтлааар оновчтой гаргаж, төрийн удирдлагын бүтцийн патrimonial хэв шинжийн давуу талыг олж авсан байна.

Чингис хааны (патrimonial) хэв маягийн төрийн удирдлага буюу засаглал нь монголчуудын хүчтэй байх үндсийг тавьж өгсөн бөгөөд энэ шинж нь Их Монгол улсын үед өөр олон хувилбараар өөрчлөгдөн хөгжих байсан боловч, Юань улсын үед монгол нутаг гурний хязгаар нутаг болон хоцрогдож, буцан уламжлалт патриархаль хэв маягт шилжсэн явдал нь цаашдаа монголын улс төрийн амьдралд муугаар нөлөөлснөөр монголчууд улс төрийн бутралын үеийг давж чадаагүй юм.

Abstract: King Chings's patrimonial ideal type state administration or governance has shown that being powerful of Mongolians. Patrimonial state administration structure was gradually appeared his life, concepts and social thinking.

Ном зүй

1. Улс төрийн шинжлэх ухаан, МУИС, УБ., 2001,
2. Монголын нууц товчоо, Ц.Дамдинсүрэнгийн орчуулга, УБ., 1947, 1976.
3. Ч.Жүгдэр. Монголд феодализм тогтох үеийн нийгэм улс төр гүн ухааны сэтгэлгээ. УБ., 2002
4. Марко Поло. Орчлонгийн элдэв сонин УБ., 1988
5. Ж.Бор. Монгол хийгээд Евроазийн дипломат шастир.УБ.,2001.
6. Плано Карпини. Монголчуудын түүх. УБ., 1988.
7. Г.Рубрук "Дорно этгээдэд зорчсон минь". 1988.
8. А.Юндэндорж. Эртний өрнө дорны мэргэдийн улс төрийн сэтгэлгээний онол. УБ.,2001.
9. Ч.Арьяасүрэн.Х.Нямбуу. Монгол ёс заншлын Их тайлбар толь.УБ.,1992
10. Д.Наран Монголын төр ёсны боловсролын түүх. 2002
11. М.Вебер. Избранные произведения. М.,
12. М.В.Масловский. Теория бюрократии Макса Вебера и современная политическая социология
13. Weber M. Wirtschaft und Gesellschaft. П.П.Гайденко., Ю.Н.Давидов. Проблемы бюрократии у Макс Вебера. //Вопросы философии. М., 1991
14. D.Bade. Khubilai khan and the beautiful princess of tumapel.UB., 2002